



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/18

Амардалай

Зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт
оруулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ын "а", 29.1.6-ын "а", "г", "л" дэх заалт, 29.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4.32, 1.12 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 183, 2016 оны 153 дугаар тогтоолын 3.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг: Коронавируст халдвар /Ковид-18/-ын тархалтын улмаас улсын хэмжээнд "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг"-т шилжүүлсэнтэй холбогдуулан жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг эдийн засгийн болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, бизнесийн тогтвортой байдал, ажлын байрыг хадгалах зорилгоор "Сум хөгжүүлэх сан"-гийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан "Хэвийн зээлийн ангилал"-тай байгаа зээлдэгчдээс төлбөр хойшлуулах хүсэлт ирүүлсэн нөхцөлд үндсэн зээлийн болон хүүгийн төлбөрийн хугацааг 2021 оны 01 дүгээр сарын 01 ны өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 01 ний өдөр хүртэл хойшлуулах хуваарьт өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: "Хэвийн зээл"-ийн ангиллаас бусад ангилалд буюу хугацаа хэтрэлттэй зээлдэгч төлөлт хийж, төлбөрийн аливаа зөрчилгүй "хэвийн зээл"-ийн ангилалд шилжсэн нөхцөлд 2021 оны 07 дугаар сарын 01 ний өдрийг хүртэл хугацаанд зээлийн төлбөрийг хойшлуулахыг мэдээлж ажиллахыг мэргэжилтэн /Ж.Саранчимэг/-т үүрэг болгосугай.

Гурав: Зээлийн эргэн төлөлтийн хугацааг тушаалын 1-д заасан төлбөр хойшлуулах хугацаагаар нэмэгдүүлж гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг мэргэжилтэн /Ж.Саранчимэг/, нягтлан бодогч /Б.Энхманлай/ нарт хариуцуулсугай.

ЗАСАГ ДАРГА

М.БАЯРСҮХ



4689100895